



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/48

Мандалговь

Аймгийн аварга малчин өрх, аварга  
тэмээчин, аварга тариаланч, шалгаруулах тухай

Сангийн сайдын 2018 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2021 оны А/21 дүгээр захирамжаар баталсан "Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журам", "Аймгийн аварга тариаланч" шалгаруулах журам, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал аж ахуйн үйлдвэрлэл, үр ашгийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг эзэмшин түүнийг боловсронгуй болгох, малын чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, мал сүргээ мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулан эрүүлжүүлэх, нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, бусдыгаа хошуучилж болзол журмыг хангасан аймгийн аварга малчин өрх, тэмээчин, тариаланчдыг нэгдүгээр, шагналын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Шагналд шаардагдах 34,500,000 /гучин дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210101